



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР**

СПОРТЫН КЛУБЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

2 дахь удаагийн хэвлэл
/АЛБАН ХЭРЭГЦЭЭНД/

Улаанбаатар хот
2020 он

СПОРТЫН КЛУБЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ
2 дахь удаагийн хэвлэл

Эмхэтгэсэн:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Ж.Баасансүрэн

Хянасан:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн дарга Г.Одбаатар

Хэвлэлийн хуудас: 2 х.х
Хэвлэсэн тоо: 400
"Содпресс" ХХК



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 03 дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар 01/178/2019

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 03 сарын 01-ны
өдрийн 136 дугаарт бүртгээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Спортын клубыг магадлан итгэмжлэх журам"-ыг нэгдүгээр, "Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт"-ийг хоёрдугаар, "Магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын бодлогын газар /Э.Мөнхбилэг/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжын газар /М. Баттүвшин/, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар /Ц.Шаравжамц/-т тус тус үүрэг болгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны "Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэлийн тухай" 363 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД

Е.БААТАРБИЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.САРАНГЭРЭЛ



СПОРТЫН КЛУБЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь спортын клубын үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт хараат бус үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, магадлан итгэмжлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагдах ба нээлттэй, ил тод, тэгш, шударга ёсны зарчимд тулгуурлана.

1.4. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клуб нь энэхүү журмын дагуу үйлчилгээний төлбөр төлнө.

Хоёр. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд спортын клубыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах орон тооны бус зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ ажиллана.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.3. Зөвлөл нь магадлан итгэмжлэлийн хараат бус шинжээчдийн дүгнэлтийг хэлэлцэж, магадлан итгэмжлэл олгох эсэх талаар дүгнэлт гаргана.

2.4. Магадлан итгэмжлэл олгох тухай зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн спортын клубын магадлан итгэмжлэл, давтан магадлан итгэмжлэл олгох, цуцлах шийдвэрийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

2.5. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь магадлан итгэмжлэлийн бодлогыг тодорхойлж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.5.1. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцогч талуудыг нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.2. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын /цаашид “Магадлан итгэмжлэгч байгууллага” гэх/ үйл ажиллагаанд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх;

2.6. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Магадлан итгэмжлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулалтаар хангаж иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэхэд орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдсэн бодлогыг тодорхойлоход дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.6.1. Спортын клубын магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд орчны эрүүл ахуй болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн чиг үүргийн дагуу хараат бус шинжээчийг гэрээний үндсэн дээр ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

2.6.2. Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд болон хичээллэгчдэд амьдралын эрүүл хэв маяг төлөвшүүлэх, сургалт, сурталчилгаа, зөвлөмжөөр хангах;

2.6.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зориулсан зөвлөмж, мэдээ, мэдээллээр хангах;

2.6.4. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй



хөдөлгөөн, биеийн тамир, спортоор үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд гарсан үр дүн, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийг тодорхойлсон эмчийн дүгнэлтэнд хяналт тавих;

2.7. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, магадлан итгэмжлэлийн чиглэлээр мэргэжлийн байгууллага болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог хангаж дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

2.7.1. Биеийн тамир, спортын чиглэлийн хараат бус шинжээчийг сонгох, сургах, давтан сургах үйл ажиллагааг зохион байгуулах;

2.7.2. Бусад мэргэжлийн байгууллагын шаардлага хангасан хараат бус шинжээчийг томилуулахаар хамтран ажиллах;

2.7.3. Хараат бус шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлтийг магадлан итгэмжлэх Зөвлөлд хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

2.7.4. Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй спортын клубын магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг хүлээн авах;

2.7.5. Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй спортын клубын үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвлөмж, мэдээ, мэдээллээр хангах;

2.7.7. Хараат бус шинжээчийн багийн дүгнэлтийг Зөвлөлөөс баталгаажуулж, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

2.7.8. Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газрыг мэргэжил арга зүйгээр хангах;

2.7.9. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубын талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

2.8. Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын болон эрүүл мэндийн газар нь тухайн нутаг дэвсгэртээ магадлан итгэмжлэлийн



чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.8.1. Спортын клубын магадлан итгэмжлэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулж идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй спортын клубын үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, мэдээ, мэдээллээр хангах;

2.8.2. Магадлан итгэмжлэлийн хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сурталчлах хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

2.8.3. Харъяа нутаг дэвсгэр дэх магадлан итгэмжлэгдсэн спортын клубын үйл ажиллагаанд явцын хяналт–шинжилгээ, үнэлгээг эрүүл мэнд, хяналтын байгууллагатай хамтран хийж, хяналтын тайланг Магадлан итгэмжлэгч байгууллагад жил тутам хүргүүлэх;

2.8.4. Спортын клубт хийгдэж буй магадлан итгэмжлэлийн үнэлгээгээр илэрсэн зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ авах, хяналт тавих;

Гурав. Магадлан итгэмжлүүлэх спортын клубт тавигдах шаардлага

3.1. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй спортын клуб нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байх;

3.1.2. Үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан, зориулалтын байранд үйл ажиллагаа явуулдаг байх;

3.1.3. Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй клуб нь тухайн спортын төрөл хариуцсан Олон улсын спортын холбооны албан ёсны гишүүн үндэсний спортын холбоонд бүртгэлтэй байх;

3.1.4. Үйлчилгээ үзүүлж буй спортын төрлөөр сургалт–дасгалжуулалтыг удирдах мэргэжлийн сургууль төгссөн болон сургалт дасгалжуулалт эрхлэх эрх авсан



- дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйчтэй байх;
- 3.1.5. Үйлчлүүлэгчийн бие бялдар, орчны эрүүл ахуйд хяналт тавих, анхан шатны болон эмнэлгийн шуурхай тусламж үйлчилгээ үзүүлэх эмчтэй байх;
- 3.1.6. Магадлан итгэмжлэлд бэлтгэх зөвлөгөөг мэргэжлийн байгууллагаас авч, зохих сургалтад хамрагдсан байх;
- 3.1.7. Магадлан итгэмжлэлийн үнэлгээ, шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийсэн байх;

Дөрөв. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах, баримт бичиг бүрдүүлэх

4.1. Спортын клуб нь магадлан итгэмжлэлд бэлтгэж, дараах баримт бичгийг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлэн Магадлан итгэмжлэгч байгууллагад хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ.

- 4.1.1. Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй спортын клубын танилцуулга;
- 4.1.2. Урьдчилсан үнэлгээ хийсэн шинжээчийн багийн хяналт, шалгалтаар зөрчил илэрсэн бол арилгах талаар арга хэмжээ авсан үр дүнгийн мэдээлэл;
- 4.1.3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажсан байх/;
- 4.1.4. Үйлчилгээ үзүүлэх спортын төрөл тус бүрээр сургалт, дасгалжуулалт эрхэлж буй талаар тухайн спортын холбоонд бүртгэлтэй эсэх;
- 4.1.5. Давтан магадлан итгэмжлэлд хамрагдах бол анхны магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар, явцын хяналт–шинжилгээ үнэлгээ хийсэн байгууллагын дүгнэлт /анх удаа орох байгууллагад хамаарахгүй/;
- 4.1.6. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээний тайлан;



4.1.7. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хийсэн дүн шинжилгээний тайлан;

4.1.8. Үйлчилгээ явуулах зориулалтын байр, заалны мэдээлэл, гэрчилгээ эсхүл өөрийн өмчлөлийн байргүй тохиолдолд 2–оос доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа, сургалт–дасгалжуулалт явуулах зорилгоор байрны өмчлөгчтэй хийсэн түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, магадлан итгэмжлэл хийлгэхийг зөвшөөрсөн тодорхойлолт;

4.1.9. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клуб нь магадлан итгэмжлэгч байгууллагаас магадлан итгэмжлэгдэх боломжтой гэсэн хариуг албан бичгээр авсны дараа энэхүү журмын дагуу үйлчилгээний төлбөрийг тус байгууллагын нэмэлт орлогын дансанд төлсөн баримт;

4.1.10. Холбогдох ажилтны /эмч, дасгалжуулагч, арга зүйч/ мэргэжлийн боловсролын диплом, бусад баримт бичиг /нотариатаар баталгаажсан байх/;

4.2. Магадлан итгэмжлэгч байгууллага нь хүсэлт гаргасан спортын клубын баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоног дотор шинжээчийн баг томилон ажиллуулах товыг гарган, спортын клубт албан бичгээр мэдэгдэнэ.

4.3. Давтан магадлан итгэмжлэлд орох спортын клуб нь батламжийн хүчинтэй хугацаа дуусахаас 90–ээс доошгүй хоногийн өмнө хүсэлтээ гаргана.

Тав. Магадлан итгэмжлэлийн үе шат

5.1. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг дараах үе шатаар хэрэгжүүлнэ.

5.2. Магадлан итгэмжлэлд бэлтгэх үе шат:

5.2.1. Спортын клуб нь магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаанд үнэлгээг хийж, үйлчилгээний чанарт тулгамдаж буй асуудлаар



чанарыг сайжруулах, түүнийг шийдвэрлэх арга хэмжээг авч, дүгнэсэн байх;

5.2.2. Урьдчилсан үнэлгээ хийсэн хараат бус шинжээчийн багийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах;

5.3. Магадлан итгэмжлэх үе шат:

5.3.1. Магадлан итгэмжлэгч байгууллага нь спортын клубын хүсэлтийг үндэслэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, шинжээч томилон ажиллуулах.

5.3.2. Хүсэлт гаргасан спортын клубын үйл ажиллагаа, үйлчилгээнд хараат бус шинжээчийн баг магадлан итгэмжлэлийг зохион байгуулах.

5.3.3. Спортын клуб дээр магадлан итгэмжлэгч байгууллагаас томилогдон ажилласан хараат бус шинжээчийн баг ажиллаж, дүгнэлтээ гаргаснаас хойш ажлын 5 хоногт багтаан магадлан итгэмжлэгч байгууллагад хүлээлгэж өгнө.

5.3.4. Зөвлөл магадлан итгэмжлэлийн хараат бус шинжээчийн багийн дүгнэлтийг хэлэлцэнэ.

5.3.5. Хэрэв давтан магадлан итгэмжлэлд орох бол магадлан итгэмжлэлд бэлтгэж, энэхүү журмын 5.2–т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Зургаа. Магадлан итгэмжлэл олгох үе шат

6.1. Биеийн тамирын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн магадлан итгэмжлэгдсэнийг баталгаажуулж, батламж олгоно.

6.2. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубын талаар Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх.

Долоо. Магадлан итгэмжлэлийн хугацаа

7.1. Магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт тус бүрийг 100 онооны үнэлгээгээр үнэлнэ. Шалгуур үзүүлэлтийн бүлэг тус бүрийн үнэлгээний босго нь анх удаа магадлан итгэмжлэлд орж байгаа спортын клубт 80 оноо ба түүнээс дээш оноо, давтан магадлан итгэмжлэлд орж буй спортын клубт 85 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд шалгуур үзүүлэлтийг хангасанд тооцно.

7.2. Анх удаа магадлан итгэмжлэгдэх спортын клуб шалгуур үзүүлэлтийг 80.0–89.9 хувь хангасан бол 1 жил, 90.0–ээс дээш хувь хангасан бол 2 жил, давтан магадлан итгэмжлэгдэх спортын клуб 90.0–94.9 хувь хангасан бол 3 жил, 95.0–иас дээш хувь хангасан бол 4 жилийн хугацаатайгаар тус тус олгоно.

7.3. Магадлан итгэмжлэгдсэний дараа клубын үйл ажиллагаа, сургалт–дасгалжуулалтын үйлчилгээний төрөл нэмэгдэх болон үйлчилгээ эрхэлдэг байр, байршил өөрчлөгдсөн, талбайн хэмжээ нэмэгдсэн тохиолдолд тухайн спортын клубт хэсэгчилсэн болон бүхэлд нь магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийнэ. Өмнөх магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа хэвээр хадгалагдана.

7.4. Спортын клубын үйл ажиллагаа, сургалт–дасгалжуулалтын үйлчилгээнд гарсан зөрчил, дутагдалтай холбоотой асуудлын улмаас магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлж, зөрчил, дутагдлыг шийдвэрлэсний дараа Зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлж, магадлан итгэмжлэл сэргээвэл өмнө нь олгосон хүчинтэй хугацаа хэвээр хадгалагдана.

7.5. Магадлан итгэмжлэлийн шаардлага хангаагүй спортын клуб 3 сарын дараа дахин хүсэлт гаргаж болно.

7.6. Спортын клубын нэр өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд үндэслэн магадлан итгэмжлэлийн батламжийг хүсэлт гаргасан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан шинэчилж олгоно.

Найм. Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох.

8.1. Магадлан итгэмжлэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно.

8.1.1. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубын үйл



ажиллагаа, сургалт–дасгалжуулалт эрхлэх үйлчилгээнд эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөний улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон талаар үйлчлүүлэгчийн гомдол гарсан, сургалт–дасгалжуулалт, үйл ажиллагаа явуулах стандарт удаа дараа зөрчигдсэн нь явцын хяналт, үнэлгээ болон хууль хяналт, шалгалт хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шалгалтаар нотлогдсон бол;

8.1.2. Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дууссан;

8.1.3. Магадлан итгэмжлэгдсэн спортын клуб, байгууллага татан буугдсан, 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоосон бол;

8.1.4. Магадлан итгэмжлэгдсэний дараа үйлчилгээ үзүүлж буй ажлын байр, сургалт–дасгалжуулалтын болон үйлчилгээний төрөл, нэмэгдсэн, өөрчлөгдсөнийг тухай бүр мэдэгдээгүй бол;

8.1.5. Бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд;


Ес. Маргааныг шийдвэрлэх

9.1. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар гарсан маргааныг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

9.2. Спортын клуб нь хараат бус шинжээчдийн багийн өгсөн дүгнэлттэй санал нийлэхгүй, эсхүл шинжээчийн ёс зүй, харилцаатай холбоотой гомдол гарвал Зөвлөлд хүсэлт гаргаж хараат бус шинжээчдийн хоёр дахь багийг томилуулж болно.

9.3. Хараат бус шинжээчийн хоёр дахь багийг томилон ажиллахтай холбогдон гарах зардлыг тухайн спортын клуб хариуцна. Энэхүү хоёр дахь багийн дүгнэлт нь Зөвлөлийн эцсийн дүгнэлт гаргах үндэслэл болно.

9.4. Спортын клуб нь Зөвлөлийн гаргасан саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гомдол гаргаж болно.



СПОРТЫН КЛУБЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Шалгуур үзүүлэлтийн ангилал

1.1. Спортын клубын магадлан итгэмжлэлийн эрх бүхий хараат бус шинжээчид магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй үйл ажиллагаа, сургалт–дасгалжуулалтын чанарт магадлан итгэмжлэлийн үнэлгээг дараах ангилал тус бүрээр үнэлж дүгнэнэ. Үүнд;

- 1.1.1. Нийтлэг шалгуур
- 1.1.2. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур
- 1.1.3. Сургалт–дасгалжуулалтын чанарын шалгуур

1.2. Магадлан итгэмжлэлийн үнэлгээний нийт үнэлгээг энэхүү журмын 1.1.1–1.1.3–т ангилсан шалгуур бүрээр тус тусад нь дүгнэх бөгөөд аль нэг ангиллын үнэлгээ 60–аас доош үнэлгээ авсан тохиолдолд магадлан итгэмжлэл олгохгүй байх үндэслэл болно.

Хоёр. Нийтлэг шалгуур

2.1. Нийтлэг шалгуур үзүүлэлт нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын Монгол Улсын холбогдох хууль стандартаар хүлээсэн нийтлэг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хүснэгтэд зааснаар үнэлгээ өгнө.



№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
1	Хууль, эрх зүйн чадамж	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, шаардлагатай бол мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	0-1	40
		Байгууллагын батлагдсан дүрэм, журам, бүтэц орон тоо, стратеги /бизнес/ үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө	0-4	40
		Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байдал	0-4	40
		Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдал	0-2	35
2	Санхүү эдийн засгийн чадамж	Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, гэрчилгээ	0-2	35
		Цалин, урамшуулал, хөдөлмөр хамгааллын нөхцөл, ажилчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	0-2	35
		Статистик, бүртгэл судалгааны материал	0-2	35
3	Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжүүлэх чадамж	Дотоод хяналт, ил тод байдлын хэрэгжилт	0-5	15
		Байгууллагын үйл ажиллагааны тайлан гаргаж, харьяа нутаг дэвсгэрийн Биеийн тамир, спортын газарт тайлагнасан байдал	0-2	15
		Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	0-5	15
4	Бусад	Нийгмийн үүрэг, хариуцлагын хэрэгжилт	0-5	10
		Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, оролцсон байдал	0-5	10

Гурав. Үйл ажиллагааны явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур

3.1. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуураар магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын үйл ажиллагаа явуулж буй барилга, байгууламж, заал, талбай, танхимын стандарт, үйлчлүүлэгчдийн идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх үеийн аюулгүй байдал, орчны эрүүл ахуйн стандартын шаардлага, хэрэгцээг хангасан байдалд өгөх үнэлгээ болно.



3.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын үйл ажиллагаа эрхэлдэг байр, талбай, заал, танхим нь өөрийн өмчлөлийн биш тохиолдолд үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуурт үнэлгээ өгөхөд өмчийн эзэмшигчийн төлөөллийг заавал байлцуулна.

3.3. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн орчны нийтлэг стандартын хэрэгжилтэнд цаашид батлагдан гарах спортын төрлийн стандартыг ишлэл болгон хэрэглэж болно.

3.4. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур:


№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
1	Спортын клубын үйлчилгээ үзүүлэх орчны нийтлэг стандартын ишлэл, хэрэгжилтийн шалгуур	Үйл ажиллагаа явуулж байгаа байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсвэл түрээсийн гэрээ	0-5	40
		Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ, Нийтлэг шаардлага MNS 5538:2005	0-3	40
		Усан бассейн, чийрэгжилтийн усан санд тавих ерөнхий шаардлага MNS 6182:2010		
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015	0-3	40
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага MNS 4996:2000	0-3	40
		Агааржуулалтын систем. Ерөнхий шаардлага MNS 0012-04-006:1985	0-3	40
		Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5525:2005		
		Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS5390:2004	0-3	40
2	Үйл ажиллагаанд мөрдөгөө болгох эрх зүйн бичиг баримт, стандартын ишлэл, судалгааны шалгуур	Цанын бааз, мөсөн гулгуурын талбайн үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандарт MNS 6000:2009	0-3	40
		Биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч. MNS 5323-12:2004	0-3	35
		Эрүүл мэндийг хамгаалах технологи, Эмчилгээ үйлчилгээний түгээмэл үйлдлүүд MNS 4621:1998	0-3	35
		Туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг ахиулах, дадлагажуулах сургалтад хамруулсан байдал	0-3	35
		Ажиллагчдын эрүүл мэнд, хувийн хэргийн бүрдүүлэлт, дэлгэрэнгүй судалгаа	0-3	35
		Батлагдсан үйлчилгээний төлбөр, хураамжийн тариф	0-3	35
		Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдал	0-3	25
		Үйлчилгээ үзүүлэх журам бусад лавлагаа мэдээллийг ил тод байрлуулсан байх	0-3	25
3	Үйл ажиллагаатай холбоотой бусад шалгуур	Санал, хүсэлт, түүний шийдвэрлэлт	0-3	25
		Ажилтан, албан хаагчдын ёс зүй, ур чадвар, харилцааны соёл	0-3	25
		Хичээллэгчдийн дэлгэрэнгүй бүртгэл, судалгаа	0-3	25
		Тухайн үйлчлүүлэгчид зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөр	0-3	25
		Мэдээлэл, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө хийсэн байдал	0-3	25
		Нийтийг хамарсан арга хэмжээ, зохион байгуулсан, оролцсон байдал	0-3	25
		Нийгмийн үйл ажиллагаанд оролцсон байдал	0-3	25

**Дөрөв. Сургалт–дасгалжуулалтын чанарын шалгуур**

4.1. Сургалт–дасгалжуулалтын чанарын шалгуурт тухайн спортын клуб сургалт–дасгалжуулалт эрхэлж буй талаар спортын холбоонд бүртгүүлсэн бүртгэл, клубын сургалт–дасгалжуулалт эрхэлж буй дасгалжуулагч, арга зүйчид тавигдах шаардлага, мэдлэг ур чадвар, үйлчилгээнд баримтлах стандартын хэрэгжилт болон хичээллэгчдийн бие бялдрын түвшин зэрэгт үнэлгээ өгнө.

4.2. Сургалт–дасгалжуулалтын үнэлгээ

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
1	Сургалт– дасгалжуулалтын үйлчилгээ эрхлэх орчны стандартын шалгуур	Тухайн төрлийн спортын холбооны бүртгэл	0–1	30
		Тухайн төрлийн стандартын хэрэгжилт	0–5	30
		Тухайн төрлийн стандартад заасан орчны шаардлага хангасан байдал /стандарт тус бүрээр/	0–5	30
		Стандартын дагуу боловсруулсан сургалт–дасгалжуулалтын төлөвлөгөө	0–5	30
2	Хүний нөөцийн мэргэжил, ур чадварын шалгуур	Дасгалжуулагчийн мэргэжил, боловсролын гэрчилгээ, ур чадварын үнэлгээ	0–3	35
		Арга зүйчийн мэргэжил, Боловсролын гэрчилгээ, ур чадварын үнэлгээ	0–3	35
		Эмчийн боловсролын гэрчилгээ	0–2	35
		Бусад шаардлагатай мэргэжлийн ажилтны мэргэжил, Боловсролын гэрчилгээ	0–3	35
		Ажилтны нийгмийн хамгаалал, бичиг баримт, хувийн хэргийн бүрдэл	0–3	35
		Дасгалжуулагч, арга зүйчийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлсэн байдал	0–5	35
		Сургалт семинар, хурал, зөвлөгөөнд оролцсон, зохион байгуулсан байдал	0–3	35
3	Сургалт дасгалжуулалтын чанарын шалгуур	Хичээллэгчдийн бие бялдрын түвшингийн үнэлгээний судалгаа	0–5	35
		Хичээллэгчдийн үзүүлсэн антропометрийн бие бялдрын хөгжлийн үндсэн үзүүлэлтийн өөрчлөлт, хэмжилт, үзүүлэлтийн судалгаа	0–5	35
		Хичээллэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа	0–5	35



СПОРТЫН КЛУБЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний төрөл	Зардлын хэмжээ /төгрөгөөр/
1	Төлбөрийн нэр: 1. Анх удаа магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын төлбөр	1,500.000
	2. Давтан магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын төлбөр	1,000.000
2	Зөвлөх үйлчилгээний төлбөр: 1. Магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны талаар зөвлөгөө өгөх, сургалтанд хамрагдах төлбөр	350.000
	2. Хараат бус шинжээчийн урьдчилсан бэлтгэл ажлын явцад арга зүйн зөвлөгөө өгөх, үнэлгээ хийсэн, тайлан бичсэн ажлын хөлс /нэг спортын клубт/	45.000
3	Шинжээчийн ажлын хөлс: 1. Хараат бус шинжээчийн багийн ахлагчийн ажлын хөлс /нэг спортын клубт нэг өдөр ажиллахад/	80.000
	2. Хараат бус шинжээчийн багийн гишүүний ажлын хөлс /нэг спортын клубт нэг өдөр ажиллахад/	60.000
4	Зөвлөлийн үйл ажиллагааны зардал: 1. Зөвлөлийн хурлын зохион байгуулалтын зардал /нэг удаагийн хуралд/	250.000
	2. Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс /нэг удаагийн хуралд ороход/	56.000



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Спортын клубын үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт магадлан итгэмжлэл явуулах зорилгоор "Спортын клубыг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Спортын клубыг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж, ажиллахыг Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтэс /Г.Одбаатар/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, санхүү хэлтэс /Ц.Одонбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ШАРАВЖАМЦ



1000000000



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Биеийн тамир,
спортын газрын даргын 2019 оны 05 дугаар
сарын 11 ны өрмийн 11/1 дугаар тушаалын хавсралт



СПОРТЫН КЛУБЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ХАРААТ БУС ШИНЖЭЭЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/178, А/144 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллана.

1.2. Спортын клубын магадлан итгэмжлэлийг явуулах биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага /цаашид магадлан итгэмжлэгч байгууллага гэх/, болон эрх олгогдсон хараат бус шинжээч /цаашид шинжээч гэх/ нь энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Хараат бус шинжээчийн багийн бүрэлдэхүүн

2.1. Спортын клубын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны магадлан итгэмжлэл хийх хараат бус шинжээчийн багийн бүрэлдэхүүнд эрүүл ахуй, орчны болон нийгмийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, боловсрол, биеийн тамир, спортын эрх бүхий шинжээчид ажиллана.

2.2. Шинжээч нь магадлан итгэмжлэгч байгууллагатай, магадлан шинжлүүлэх байгууллагын удирдлага, багш, дасгалжуулагч, арга зүйч, эмч, гишүүдтэй ашиг сонирхолын зөрчилгүй, төрөл садан биш байна.

Гурав. Хараат бус шинжээчийг сонгох шалгуур

3.1. Өмчийн бүх хэлбэрийн байгууллагын шинжээч, иргэд нэрээ нээлттэй дэвшүүлнэ.

3.2. Шинжээчийг 2 жил тутамд нээлттэй зарлаж сонгоно.



3.3. Шинжээч нь дараах шаардлага, ур чадварыг хангасан байна.

3.3.1. мэргэжлийн, бакалавр түүнээс дээш зэрэгтэй;

3.3.2. тухайн мэргэжлийн чиглэлээр 10–аас дээш жил ажилласан, дадал, туршлагатай байх;

3.3.3. байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, багаар ажиллах чадвартай байх;

3.3.4. биеийн тамир, спортын салбараас бусад 2.1–д заасан салбарын эрх бүхий шинжээчийн эрхийн баримт бичгийн хуулбар нотариатаар баталгаажуулсан байх;

3.4. Шинжээчээр ажиллах хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ.

3.4.1. хүсэлт;

3.4.2. төрийн албан хаагчийн анкет;

3.4.3. иргэний үнэмлэхний хуулбар;

3.4.4. боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/;

3.4.5. шинжээчээр ажиллахыг дэмжсэн байгууллага, хамтран ажиллаж байсан 2 хүний тодорхойлолт;

3.4.6. 2 хувь цээж зураг /сүүлийн 6 сарын дотор авахуулсан/;

Дөрөв. Хараат бус шинжээчийн үйл ажиллагаа

4.1. Магадлан итгэмжлэх байгууллага нь шалгуур хангасан этгээдэд шинжээчийн эрхийг 3 жилийн хугацаагаар олгоно.

4.2. Магадлан итгэмжлэх байгууллагаас шинжээчийг магадлан шинжлэх аргазүйн сургалтад хамруулна.

4.3. Магадлан итгэмжлэх байгууллага нь биеийн тамир, спортын байгууллагад магадлан шинжилгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж, шинжээчид 2 долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.

4.4. Магадлан итгэмжлэх байгууллага нь магадлан шинжилгээнд оролцсон хугацаа, ажлын үр дүнг харгалзан шинжээчид ажлын хөлс олгоно.

Тав. Хараат бус шинжээчийг ажиллуулах, магадлан шинжлэх, үнэлгээ хийх

Магадлан итгэмжлэх байгууллага нь эрх бүхий шинжээчээс ашиг сонирхолын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг гаргуулан гэрээ байгуулж ажиллуулна.

5.1. Спортын клубын магадлан итгэмжлэлийг явуулах биеийн тамир, спортын шинжээчээс бусад мэргэжлийн байгууллагын шаардлага хангасан эрх бүхий шинжээчийг гэрээгээр авч ажиллуулна.

5.2. Спортын клубын магадлан итгэмжлэлийн эрх бүхий шинжээчид магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубын иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт магадлан итгэмжлэлийн үнэлгээ явуулна.

5.3. Спортын клубын үйлчилгээний төрөл, цар хүрээнээс хамаарч 3-5 хараат бус шинжээчийн бүрэлдэхүүнтэй баг нэг клубт 1-3 өдөр ажиллана.

5.4. Шинжээчийн баг магадлан шинжлүүлэх байгууллагын удирдлага, ажилтнуудад ажлын төлөвлөгөөг танилцуулан, үнэлгээг хийж, төлөвлөгөөний дагуу ажиллана.

5.5. Шинжээчийн баг нь ажиглалт, ярилцлага, баримт бичгийн үзлэг хийх, үнэлгээг шалгуур үзүүлэлтийн хуудастай тулгах зэрэг аргуудыг үнэлгээнд ашиглана.

5.6. Шинжээчийн баг нь үнэлгээтэй холбоотой нэмэлт баримт бичгийг тухайн байгууллагаас гаргуулан авч болно.

5.7. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр хийгдсэн үнэлгээний урьдчилсан дүгнэлт, сайжруулах ажлын зөвлөмжийг 2 хувь тэмдэглэл үйлдэн тухайн байгууллагын удирдлага, ажилтнуудад танилцуулж, байгууллагад нэг хувийг үлдээнэ.

5.8. Магадлан итгэмжлэгч байгууллага нь шинжээчийн багийн ирүүлсэн баримт бичгийг хянаж, орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг бэлтгэн хүргүүлнэ.

5.9. Орон тооны бус зөвлөлөөс гаргасан нэгдсэн дүгнэлтийг үнэлгээ хийснээс хойш ажлын 10 хоног, шийдвэрийг спортын клубт



ажлын 5 хоногт хүргүүлнэ.

5.10. Магадлан итгэмжлэх байгууллага нь магадлан итгэмжлэгдсэн спортын клубын мэдээллийг байгууллагын албан ёсны сайтад байршуулан олон нийтэд мэдээлнэ.

Зургаа. Шинжээчийн эрхийг сунгах, хүчингүй болгох

6.1. Шинжээч нь магадлан шинжилгээг мэргэшлийн өндөр түвшинд хийж, мэргэжлийн зөрчил гаргаагүй бол магадлан итгэмжлэх байгууллага нь шинжээчийн эрхийг 2 жилийн хугацаагаар дахин сунгана.

6.2. Шинжээч нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдсон, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд шинжээчийн эрхийг хүчингүй болгоно.





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

□ Журам, төлбөрийн хэмжээ батлах тухай □

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12, 9.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.8, 14.9.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний урамшуулалд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх урамшууллын хэмжээ"-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Г.Баясгалан)-т ДААЛГАХ нь:

2.1. Даатгуулагчид идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэгдсэн спортын клубуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах, сонгон шалгаруулалтад тэнцсэн спортын клубтэй даатгалын гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.2. Төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын байгууллага болон спортын клубыг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, иргэд, даатгуулагчид сурталчлах, мэдээлэл хүргэх ажлыг холбогдох газруудтай хамтран шуурхай зохион байгуулж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулах;

2.3. Тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан эрүүл мэндийн даатгалын цахим систем, програм хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах;

2.4. Даатгуулагчид идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэгдсэн спортын клубуудын гэрээний хэрэгжилтийн явц, тайланг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралд дараа оны нэгдүгээр улиралд багтаан танилцуулах;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-д даалгасугай.

ДАРГА



Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн даатгалын Үндэсний
зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 13-ны
өдрийн 19 дүгээр тогтоолын нэгдүгээр

хавсралт

1117149846
ТУЗ0045.2 5284708

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН СПОРТЫН КЛУБТ ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгалын гэрээ бүхий магадлан итгэмжлэгдсэн спортын клуб /цаашид “спортын клуб” гэх/-т идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, үйлчилгээ /цаашид “үйлчилгээ” гэх/-нд хамрагдсан даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сан /цаашид “даатгалын сан” гэх/-аас урамшуулал олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1–6.1.4, 6.1.9, 6.1.12–т заасан даатгуулагч /цаашид “даатгуулагч” гэх/ нь нэг удаадаа 1 цагаас доошгүй хугацаагаар, 3 сарын турш 24–өөс доошгүй удаа спортын клубын үйлчилгээнд хамрагдсан тохиолдолд энэхүү урамшуулал авах эрх үүснэ.

1.3. Даатгалын сангаас урамшуулал олгох “Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний жагсаалт”–ыг эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.8 дахь хэсэгт заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл батална.

1.4. “Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний жагсаалт”–д багтсан үйлчилгээний төрөл /цаашид “үйлчилгээний төрөл” гэх/-д оюун ухааны хөгжлийг дэмжсэн спорт, олимпын болон тэмцээн уралдаанд оролцоход зориулагдсан үйлчилгээний төрөл хамаарахгүй.



Хоёр. Даатгуулагчийн эрх, үүрэг

2.1. Даатгуулагч нь дараах эрхтэй байна.

2.1.1. Спортын клубт харьяалал харгалзахгүй үйлчлүүлэх, чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй үйлчилгээ авах;

2.1.2. Эрүүл мэндийн даатгалын цахим хуудсаар дамжуулан спортын клубын мэдээлэл, үйлчилгээний жагсаалт, цагийн хуваарьтай танилцах, спортын клубыг сонгож бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд цаг авах;

2.1.3. Энэ журмын 1.3–т заасан үйлчилгээний жагсаалтаас аль нэгийг сонгон үйлчлүүлэх, хэрэв сонгосон үйлчилгээний төрөл нь өөрийн эрүүл мэндэд нь сөрөг нөлөө үзүүлж, өөрчлөх шаардлага үүсвэл тухайн спортын клубын эмчийн заалтаар өөрчилж болно;

2.1.4. Спортын клубт төлсөн НӨАТУС бүхий төлбөрийн баримтыг тухайн спортын клубээс гаргуулах;

2.1.5. Энэ журмын 1.2–т заасан эрх үүссэн тохиолдолд даатгалын сангаас урамшууллын зардлыг авах;

2.1.6. Спортын клубын үйлчилгээ болон эрүүл мэндийн даатгалын талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авах;

2.1.7. Хууль, журам, заавар зөрчсөн, чанарын шаардлага хангаагүй үйлчилгээг үзүүлсэн, НӨАТУС бүхий баримт олгоогүй зэрэг зөрчил гаргасан спортын клубын талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага болон холбогдох хяналтын байгууллагад гомдол гаргах;

2.2. Даатгуулагч нь дараах үүрэгтэй байна.

2.2.1. Спортын клубт өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил өгч, биеийн тамирын аргазүйч–багш, дасгалжуулагч, эмчийн заасан хөтөлбөр, зааврын дагуу үйлчилгээнд бүрэн хамрагдах, үр дүнг тооцуулах;

2.2.2. Спортын клубын үйлчилгээнд хамрагдахын өмнө



- өөрийн холбогдох мэдээллийг үнэн зөв бүртгүүлэх;
- 2.2.3. Үйлчлүүлэх бүртээ тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагаа эрүүл мэндийн даатгалын цахим системд хурууны хээ уншигч төхөөрөмжөөр бүртгүүлэх;
- 2.2.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, спортын клубын хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

Гурав. Спортын клубын эрх, үүрэг

3.1. Спортын клуб нь дараах эрхтэй байна.

- 3.1.1. Энэ журам болон эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээний заалт, эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар санал, хүсэлт гаргах;
- 3.1.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүй, харьцаа хандлагын талаар гомдол гаргах;
- 3.1.3. Даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих.

3.2. Спортын клуб нь дараах үүрэгтэй байна.

- 3.2.1. Энэхүү журам, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж, стандартыг баримтлан даатгуулагчийн эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн хөтөлбөр, заавар боловсруулан баталгаажуулж, харьяалал харгалзахгүй чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх;
- 3.2.2. Даатгуулагчид үйлчилгээ үзүүлж эхлэхийн өмнө болон дууссаны дараа бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах, мэргэжил аргазүйгээр хангах, үр дүнг үнэн зөв тооцож ажиллах;
- 3.2.3. Мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангах, эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдож, өөрийн болон даатгуулагчийн холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулах;
- 3.2.4. Даатгуулагчид үйлчилгээ үзүүлэх бүртээ тухайн

өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ уншигч төхөөрөмжөөр бүртгэх;

3.2.5. Даатгуулагчид тухайн үйлчилгээнд төлсөн төлбөрийн НӨАТУС бүхий баримтыг олгох;

3.2.6. Үйлчилгээнд хамрагдаж, даатгалын сангаас урамшуулал авах эрх үүссэн даатгуулагчийн мэдээллийг цахим хэлбэрээр хөтөлж, хадгалах;

3.2.7. Өөрийн хаяг, байршил, талбайн хэмжээ, хүний нөөц, тоног төхөөрөмж, үйлчилгээний чиглэл, төлбөрийн талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагад үнэн зөв мэдүүлэх, өөрчлөлт орсон тохиолдол бүрт албан бичгээр ажлын 10 хоногийн дотор мэдэгдэх;

3.2.8. Зохион байгуулж буй үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэл, төлбөрийн талаарх мэдээллийг ил тод, ойлгомжтой хэлбэрээр цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, даатгуулагчийг үнэн зөв мэдээллээр хангах;

3.2.9. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай хамтран эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2.10. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

4.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах эрхтэй байна.

4.1.1. Спортын клубыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн баталсан журмын дагуу сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтад тэнцсэн спортын клубтэй даатгалын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, цуцлах;

4.1.2. Спортын клубын үйл ажиллагаа, даатгуулагчдад



үзүүлсэн үйлчилгээний чанар, үр дүн, зардлын төлбөр, холбогдох баримт бичиг, гэрээний хэрэгжилтэд цахим болон цаасан хэлбэрээр хяналт тавих, дүгнэлт гаргах, зөвлөмж заавар өгөх;

4.1.3. Спортын клубын буруутай үйл ажиллагааны улмаас даатгуулагчийн эрүүл мэнд болон даатгалын санд хохирол учруулсан нь тогтоогдвол тухайн спортын клубт холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

4.1.4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Биеийн тамир, спортын газар болон даатгалын харилцаанд оролцогч спортын клубээс албан ёсны статистик мэдээлэл, хаяг, байршил, үйлчилгээний чиглэл, төлбөрийн хэмжээ болон бусад шаардлагатай мэдээллийг авч судлах, үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх;

4.1.5. Спортын клуб болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих;

4.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах үүрэгтэй байна.

4.2.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, спортын клубын хооронд мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангаж, цахим системд нэвтрэх эрх олгох, даатгуулагчид цахимаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.2. Энэхүү журмын 1.2-т заасан эрх үүссэн даатгуулагчид урамшууллын зардлыг эрүүл мэндийн даатгалын цахим системд бүртгүүлсэн харилцах дансанд нь ажлын 20 хоногт багтаан шилжүүлэх;

4.2.3. Даатгалын харилцаанд оролцогч спортын клубын тоо, үйлчлүүлэгчийн тоо, үйлчилгээний чиглэл, чанар,

өмнөх оны гүйцэтгэл, хүчин чадал болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн спортын клубын үйлчилгээнд шаардагдах төсвийн хэмжээг боловсруулж, даатгалын сангийн зарлагын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх;

4.2.4. Даатгуулагч болон спортын клубээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хуулийн дагуу шийдвэрлэх, даатгалын харилцаанд оролцогч талуудыг үнэн зөв мэдээллээр хангах;

4.2.5. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг спортын клубтэй хамтран зохион байгуулах;

Тав. Хориглох зүйл

5.1. Даатгуулагчид дараах зүйлийг хориглоно.

5.1.1. Өөрийн сонгосон үйлчилгээг тасалдуулах, үйлчилгээг дур мэдэн өөрчлөхийг шаардах, буруу, ташаа мэдээлэл өгөх;

5.1.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын болон спортын клубын эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлага, энэ журамд заасан үүргийг биелүүлэхгүй байх;

5.2. Спортын клубын үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно.

5.2.1. Ашиг, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагчтай үгсэн хуйвалдаж, шаардлагагүй болон түүний өвчний онош, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд тохироогүй үйлчилгээг үзүүлэх, зөвлөх, буруу, ташаа мэдээлэл өгөх, тулган шаардах;

5.2.2. Биеийн тамирын арга зүйч-багш, дасгалжуулагч, эмчлэх зөвшөөрөлгүй этгээдийг үйл ажиллагаанд татан оролцуулах, хуурамч бичиг баримт үйлдэх, даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах үйлчилгээний жагсаалт, холбогдох баримт, тайланг худал мэдүүлэх;



5.2.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох хяналтын байгууллагын эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлага, энэ журамд заасан үүргийг биелүүлэхгүй байх;

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагч хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.


6.2. Даатгуулагчийн холбогдох мэдээлэл алдаатай бүртгэгдсэний улмаас даатгалын сангаас урамшууллын зардал олгоогүй бол буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагч хариуцлага хүлээнэ.

6.3. Журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн даатгалын гэрээгээр зохицуулна.





Эрүүл мэндийн даатгалын Үндэсний
зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 13-ны
өдрийн 19 дүгээр тогтоолын хоёрдугаар
хавсралт



**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН СПОРТЫН КЛУБТ ИДЭВХТЭЙ
ХӨДӨЛГӨӨН, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ТӨЛӨХ
УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	Тусламж, үйлчилгээний нэр	ЭМДС-аас төлөх нэг удаагийн төлбөрийн хэмжээ /төгрөг/
1	Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ	60 000





ГАРЧИГ

1. Спортын клубыг магадлан итгэмжлэх журам батлах тухай
3 – 17
2. Спортын клубыг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журам батлах тухай
18 – 22
3. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох журам, төлбөрийн хэмжээ батлах тухай
23 – 31